

Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрийн
2017 оны бүртгэл эхэлсэн тухай
Хэвлэлийн мэдээ

1. “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр” -ийн 2017 оны бүртгэлийг 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн зарлаж байна. Өргөдлийн маягт хүлээж авах эцсийн хугацаа:

Докторын элсэгч: [9-р сарын 29 \(Баасан\) хүртэл](#)

Магистрын элсэгч: [11-р сарын 15 \(Лхагва\) хүртэл](#)

2. Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр нь хөгжиж буй орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд гар бие оролцох, ирээдүйд чухал үүрэг гүйцэтгэх залуу төрийн албан хаагчдыг Япон улсын их, дээд сургуулийн магистр, докторын түвшний хөтөлбөрт суралцуулах замаар мэргэшүүлэн бэлтгэж, төгсөөд өөрийн улсад тулгарч буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг бодитойгоор шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах, цаашлаад Япон хүмүүстэй харилцаа холбоо тогтоон, ирээдүйд хоёр улсын түншлэлийг бэхжүүлэхэд хөтөлбөрийн зорилт оршино. Энэхүү хөтөлбөр нь 1999 оноос шинээр хэрэгжиж эхэлсэн буцалтгүй тусламжийн хөтөлбөр бөгөөд өдгөө Зүүн Өмнөд Азийн орнууд зонхилсон 13 улсад хэрэгжиж, нийт 3,000 гаруй залуус Япон улсад суралцаад байна.
3. Энэхүү хөтөлбөр нь Монгол улсад 2001 оноос хэрэгжиж эхэлсэн ба өнөөг хүртэл нийт 300 оюутан залуус Япон улсад суралцаад байна. Үүнээс 244 оюутан төгсөж ирээд Засгийн газрын холбогдох байгууллагууд, Их дээд сургуулиуд, Төв банк зэрэг нийгмийн олон салбарт үр бүтээлтэй ажиллаж байна.
4. Энэхүү жил JDS хөтөлбөрөөр төрийн байгууллагаас 18 хүн, хувийн хэвшлээс (Зөвхөн Япон хэл дээр) 2 хүн, нийт 20 магистр оюутан, мөн дээд тал нь 2 доктор оюутныг сонгон шалгаруулж, Япон улсын их, дээд сургуульд илгээж, тус тусын мэргэжлээр Англи хэл дээр (Магистр: 2 жил, Доктор: 3 жил) суралцах болно.
5. 9-р сарын дундаас 10-р сарын эхэн хүртэл төслийн гол хамрагдах байгууллага болон Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв дээр элсэлтийн танилцуулга семинарыг зохион байгуулах болно.
6. JDS хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүйг, мөн танилцуулга семинарын хуваарийг дараах цахим хуудаснаас харна уу. <http://jds-scholarship.org/>